

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Г “Соёмбо инк даатгал” ХХК-ийг “Түшиг даатгал” ХХК-д 7 нэгдэхийг зөвшөөрч, “Соёмбо инк даатгал” ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Даатгалын тухай хуулийн 13.1.2, 75.1, 78.2.2 Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 76 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчаас үйл ажиллагааны тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Соёмбо инк даатгал” ХХК-ийг “Түшиг даатгал” ХХК-д нэгдэхийг зөвшөөрсүгэй.
2. Хоёр компани нэгдсэнтэй холбогдуулан “Соёмбо инк даатгал” ХХК-ийн 2010 онд хийсэн таван байгууллагын 24937,2 сая төгрөгийн даатгалын үнэлгээтэй 10 даатгалын гэрээг “Түшиг даатгал” ХХК-ийн нэр дээр шилжүүлж, хоёр компанийн нэгдсэн тайлан, шилжүүлсэн даатгалын гэрээ, компанийн шинэчилсэн дүрмийг 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Түшиг даатгал” ХХК /М.Жалавдорж/-д үүрэг болгосугай.
3. “Соёмбо инк даатгал” ХХК-ийг “Түшиг даатгал” ХХК-д нэгдэх үйл ажиллагаанд хяналт тавьж, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т үүрэг болгосугай.
4. “Соёмбо инк даатгал” ХХК-ийг “Түшиг даатгал” ХХК-д нэгдэхийг зөвшөөрсөнтэй холбогдуулж тус компанийн 2/17 дугаартай ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож татан буулгахыг зөвшөөрсүгэй.
5. “Түшиг даатгал” ХХК-ийн дүрмийн санг дараах байдлаар бүрдүүлснийг зөвшөөрсүгэй:

№	Компанийн хөрөнгө оруулагч хувь нийлүүлэгч иргэн, байгууллагын нэр	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ (төгрөг)	Нийт хувьцааны үнэ (төгрөг)	Дүрмийн санд эзлэх хувь
---	--	----------------------	-----------------------------	-----------------------------	-------------------------

1	“Ой мод” ХХК	255929	1000	255.929.000	24.41%
2	Думаажавын Батбаяр	237681	1000	237.681.000	22.67%
3	Мухлашийн Жалавдорж	54846	1000	54.846.000	5.23%
4	Цэрэнчанаагийн Баттулга	500000	1000	500.000.000	47.69%
	Дүн	1048456		1.048.456.000	100.00%

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН